

Ажлын удирдамж

Судалгааны төслийн нэр	Монгол Улсын агаарын тээврийн салбарын либералчлал ба холбогдох салбаруудын уялдаа холбоо, цогц хөгжлийн бодлого
Байршил	Улаанбаатар хот, Монгол Улс
Зарлагдаж буй ажлын байрны нэр	Төслийн зөвлөх (2 хүн)
Гэрээний төрөл	Individual Contractor (IC) – Бие даасан гэрээт гүйцэтгэгч
Судалгааны ажлыг гүйцэтгэх хэл:	Монгол
Гэрээний үргэлжлэх хугацаа	31 хоног

Үндэслэл

Дэлхийн нийт худалдааны 80 гаруй хувийг далайн худалдаа эзэлж буй өнөө цагт Далайд гарцгүй хөгжиж буй орнууд (ДГХБО) худалдаа, хөгжлийн томоохон бэрхшээлтэй тулгарч байгаа юм. Газарзүйн хувьд өөрчлөх боломжгүй саад бэрхшээлтэй тулгардаг эдгээр орнуудад Ковид-19 цар тахлын үр нөлөө дэлхийн бусад орнуудаас ч илүү хүнд тусах магадлалтай гэдгийг Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ) зэрэг олон улсын томоохон институцүүд сэрэмжлүүлсээр байгаа билээ.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас гаргасан 2021 оны 1-р улирлын тайланд мэдээлснээр Ковид-19 цар тахал болон хатуу хөл хорионы улмаас Монгол Улсад бүх төрлийн тээврээр зорчигчид давхардсан тоогоор 19.8 сая хүн болж, өмнөх оны мөн үеэс зорчигч 9.3 сая хүн буюу 30.4%-иар буурсан байна. Ялангуяа манай улсын хувьд олон улсын зах зээлтэй шууд холбогдох цорын ганц үүд хаалга болдог агаарын тээврийн салбар цар тахлаас болж урьд өмнө тулгарч байгаагүй хүнд нөхцөл

байдалтай нүүр тулгарч байна. Агаарын тээврээр 2021 оны эхний улиралд зорчигчид 25.2 мянган хүн болж, өмнөх оноос 190.6 сая хүн буюу 88.3%-иар буурчээ.

Харин тус салбарын орлогын хувьд 2021 оны эхний улирлын орлого 25.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 26.8 тэрбум буюу 58.1%-иар буурсан байна. Агаарын тээврээр тээвэрлэсэн ачаа болон шуудан тээвэрлэлтийн хэмжээ ч огцом унасан бөгөөд 2021 оны эхний улиралд 731.3 тонн ачаа болон шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 352 тонн буюу 32.5%-иар буурсан үзүүлэлт юм.

Монгол Улсын Иргэний агаарын тээврийн салбар сүүлийн жилүүдэд хурдацтай өсч байсан боловч Ковид-19 цар тахлын улмаас салбарын үзүүлэлт огцом буурч, 2020 оны салбарын тоон үзүүлэлт нь 2009 оны түвшинд хүрээд байна. Цар тахлын нөлөөгөөр 2020 онд олон улсын чиглэлийн нислэгүүд зогссоноос үүдэн 161,804 зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос зорчигчийн тоо 86%-иар буурсан үзүүлэлт аж.

Маш хүнд нөхцөл байдалтай тулгарч буй уг салбарыг цар тахлын дараа хэрхэн сэргээх вэ гэдэг асуулт үүсч байгаа юм. Харин агаарын тээврийн салбарыг либералчлах асуудлыг хэлэлцсээр ирсэн бөгөөд либералчлах үйл явцыг эрчимжүүлбэл өнөөгийн үүсээд буй нөхцөл байдлыг давж гарахад эерэг нөлөө үзүүлэх өөрчлөлт болж чадах эсэхийг судалгаа, шинжилгээ дээр тулгуурлан олж мэдэх шаардлага бий болж байна. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төв нь Төв Азийн далайд гарцгүй хөгжиж буй таван улсын агаарын тээврийн зах зээлд судалгаа хийсэн бөгөөд уг судалгаагаар агаарын тээврийн салбарыг зөв төлөвлөгөөний дагуу либералчлах нь ашигтай гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг.

Агаарын тээврийн салбар дахь либералчлалыг эрчимжүүлсний үр дүнд маршрут, авиа компани болон онгоцны тоог нэмэгдүүлээ гэж үзэхэд зорчигчдын тоог хангалттай нэмэгдүүлж, ашиг олох боломж, чадавх болон нөөц бололцоо байгаа эсэхийг судлах нь энэхүү судалгааны үндсэн зорилго болно. Мөн агаарын тээврийн салбарыг либералчлах асуудал нь дан ганц нисэхийн салбарыг авч хэлэлцсэнээр шийдэгдэх асуудал биш юм. Агаарын тээврийн салбарт либералчлалыг эрчимжүүлбэл аялал, жуулчлалын салбарт хэрхэн нөлөөлөх, хангалттай жуулчид, зочид татах боломж, бололцоо ямар түвшинд байна вэ, цаашилбал жуулчдын тоо нэмэгдвэл хүлээн авах чадамж, үзвэр үйлчилгээ болон дэд бүтцийн салбарын нөхцөл байдал ямар байна вэ гэдгийг судалж, мэдэх шаардлагатай байгаа юм.

ДГХБО-ын ОУСТ-өөс Монгол Улсын агаарын тээврийн салбарын либералчлал болон уг салбартай холбогдох бусад салбарын уялдаа холбоо, хэтийн төлөв, замын зургийг тодорхойлсноор Монгол Улсын Гадаад харилцааны яам; Зам, тээврийн хөгжлийн яам; Байгаль орчин, аялал жуулчлалын яам; Соёлын яам; Иргэний нисэхийн ерөнхий газар болон бусад төрийн болон төрийн бус

байгууллагууд энэхүү замын зургыг ашиглан Алсын хараа 2050 Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд хувь нэмэр оруулах судалгаа болох юм.

Өмнө нь агаарын тээврийн салбарын либералчлалын талаар болон далайд гарцгүй хөгжиж буй орнуудын бусад асуудлын хүрээнд өндөр зэрэглэлийн судалгааг удирдан гүйцэтгэсэн арвин туршлагатай, бие даасан хараат бус олон улсын судалгааны байгууллага болох ДГХБО-ын ОУСТ нь энэ хүрээнд уг судалгааг боловсруулж, өндөр түвшний бодлогын зөвлөмжийг гүйцэтгэх төслийн зөвлөхийг (2 хүн) гэрээт гүйцэтгэгчээр сонгож ажиллуулах юм.

Судалгааны зорилго

Энэ судалгааны гол зорилго нь Ковид-19 цар тахлын дараа агаарын тээврийн салбарыг сэргээж, буцаж өсөлтөд хүргэхэд шаардлагатай roadmap буюу хөгжлийн замын зураг болсон цогц бодлогын зөвлөмжийг боловсруулахад оршино. Тус салбарын сэргэлт, өсөлтийн асуудалд агаарын тээврийн либералчлалын талаар дэлгэрэнгүй авч үзэх шаардлагатай бөгөөд ингэхийн тулд аялал жуулчлал, зам тээврийн дэд бүтэц болон үйлчилгээний салбарын уялдаа холбоог судалж, тодорхойлох ёстой. Судалгааны үр дүнд дээрх салбар тус бүрд зориулсан бодлогын зөвлөмж гарах ба эцэст нь эдгээр салбарын хөгжлийн уялдаа холбоог нэгтгэсэн цогц хөгжлийн бодлого бүхий бодлогын зөвлөмж гарах юм.

Судалгааны хамрах хүрээ

Монгол Улсын агаарын тээвэр, аялал, жуулчлал, үйлчилгээний болон зам тээврийн дэд бүтцийн салбарын хөгжлийн бодлогыг уялдуулж, үр дүнд нь цогц хөгжлийн бодлого бүхий бодлогын зөвлөмжийг гаргана. Эдгээр салбарыг уялдуулсан цогц бодлогын зөвлөмж гарах ёстой тул салбар тус бүрд эмпирик дүн шинжилгээ хийж, бодлогын зөвлөмж гаргана.

- **Агаарын тээврийн салбарын** эмпирик дүн шинжилгээ, зөвлөмжийн хэсэгт авч үзэх ёстой эсвэл хэлэлцэж болох тодорхой асуудлууд бий. Ковид-19 цар тахлын агаарын тээврийн салбарт үзүүлж буй үр нөлөө, агаарын хилээ нээсний дараагаар манай орныг зорих хүмүүсийг нэмэгдүүлэх ямар боломж байгаа талаар. Мөн Монгол Улс агаарын тээврийн либералчлалыг эрчимжүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлсэн тохиолдолд тэдгээр нэмэгдсэн нислэгийн хүрээнд хэдий хэмжээний зорчигчид ирэх боломжтой талаар дата, тоон мэдээллийг судлах.
- Агаарын тээврийн салбарын либералчлалын хүрээнд нислэгийн тоог нэмэгдүүллээ гэж үзэхэд жуулчид, зочдыг татахын тулд **аялал, жуулчлалын салбарт** ямар төлөвлөгөө хэрэгтэй вэ? Аялал, жуулчлалын тодорхой ямар бүтээгдэхүүн бидэнд байна вэ? Зун, өвөл гээд дөрвөн улирлын туршид

жуулчдыг татах боломж бололцоог дүгнэх, (жнь: Наадам, Мөсний баяр, Бүргэдийн баяр, Мянган тэмээний баяр зэрэг бусад фестиваль, үзвэр г.м) улирлын чанартай урлаг соёлын арга хэмжээ, баяр наадмыг олон улсын стандартад нийцүүлэх, баяжуулах, төрөлжүүлэхийн тулд хийх шаардлагатай ажлуудыг судлах. Соёлын салбар ямар үүрэгтэй оролцохыг давхар дүгнэх. Ялангуяа, conference tourism буюу олон улсын хурал, уулзалтыг Монголд зохион байгуулах замаар жуулчид, зочдын тоог нэмэгдүүлэх боломжийг судлах; ямар хурал, уулзалтыг татаж болох талаар судлах (НҮБ-ийн системийн байгууллагууд болон бусад олон улсын байгууллагуудын чуулган, бага хурал, сургалт семинар зэрэг); энэ аргыг амжилттай хэрэгжүүлсэн орнуудын эмпирик судалгаа дээр тулгуурлаж зөвлөмж гаргах зэрэг багтаж болно. Мөн тур операторуудтай хамтран ажиллаж, дэмжих боломж бололцоог судлах зэрэг багтах боломжтой.

- Аялал, жуулчлалын салбар жуулчдын тоог нэмэгдүүлсэн тохиолдолд **үйлчилгээний салбарын** чадавх, боломж, бололцоог үнэлэх, хэрэгжүүлэх боломжтой, шаардлагатай бодлогуудын талаар зөвлөмж гаргах.
- **Зам тээвэр, дэд бүтцийн** хувьд ямар асуудал байгааг тодорхойлж, эмпирик дүн шинжилгээ, зөвлөмж гаргах.
- Дээр дурдсан салбар тус бүрд зөвлөмж боловсруулсны үр дүнд дээрх салбаруудын хоорондын уялдаа холбоог тодорхойлж, нэгтгэсэн, өөрөөр хэлбэл уялдуулсан хөгжлийн бодлого бүхий **бодлогын зөвлөмжийг** боловсруулна.

Төслийн зөвлөхийн гүйцэтгэх үүрэг болон даалгавар:

- Судалгааны санал боловсруулж, судалгааны арга зүй болон дэлгэрэнгүй төлөвлөгөөг ДГХБО-ын ОУСТ-д танилцуулж, батлуулах;
- Судалгаанд шаардлагатай мэдээлэл, эх сурвалжийг олж, цуглуулж, боловсруулах;
- Тайлан боловсруулалтыг дуусгаж, судалгааны тайлангийн төслийг (draft) танилцуулах;
- ДГХБО-ын ОУСТ-ийн судалгааны тайлангийн төсөлд өгсөн санал, шүүмжийг тусган судалгааны тайланг эцэслэж, ДГХБО-ын ОУСТ-д хүлээлгэж өгөх болно.

Судалгааны гэрээт ажлыг гүйцэтгэх хугацаа

Хугацаа	Үе шат
2021.07.05	ДГХБО-ын ОУСТ-тэй гэрээ байгуулах
2021.07.10	Судалгааны дэлгэрэнгүй төлөвлөгөөг танилцуулах
2021.08.05	Тайлан боловсруулалтыг дуусгаж, судалгааны тайлангийн төслийг хүлээлгэн өгөх
2021.08.10	Тайланг эцсийн хувилбараар захиалагчид хүлээлгэн өгөх

Гэрээ үргэлжлэх хугацаа

Судалгааны ажлыг 2021 оны 07 сарын 05-аас 2021 оны 08 сарын 10-ны хооронд дуусгах ёстой.

Төлбөрийн нөхцөл

- Судалгааны дэлгэрэнгүй төлөвлөгөөг хүлээн авсны дараа судалгааны төлбөрийн дөчин хувь (40%)-ийг судалгааг хийхээр сонгогдсон зөвлөхийн дансанд шилжүүлнэ.
- Эцсийн шатны хэлэлцүүлгийг хийж тайланг эцсийн хувилбараар захиалагчид хүлээлгэн өгсний дараа жаран хувь (60%) – ийг судалгааг хийхээр сонгогдсон зөвлөхийн дансанд шилжүүлнэ.

Судалгааны ажилд тавигдах шаардлага

- Судалгааны ажил нь өндөр чанартай, найруулга болон бичиг үсгийн дүрмийн хувьд зөв бичигдсэн, тодорхой бөгөөд ойлгомжтой байна;
- Судалгааны ажлыг Монгол хэл дээр Word ашиглан бичих ба форматын хувьд Arial фонт, 12 хэмжээтэй, гарчгийн зай 1.0 байна.
- Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн арга зүйг ашиглан гүйцэтгэх;
- Судалгааны ажлын эхэнд executive summary буюу ерөнхий хураангуйг оруулсан байх;
- Судалгааны ажил хэсэг бүрчлэн дүгнэлт, зөвлөмжтэй байх бөгөөд судалгааны эцэст нэгдсэн дүгнэлт, санал, зөвлөмжийг гаргах;
- Судалгааны ажилд ашигласан баримт, мэдээллүүдийн эх сурвалж тодорхой байх;
- APA, Chicago, MLA ишлэлийн загвараас сонгож ажиллах;
- Уг судалгааны ажлыг цаашид ашиглах, бусдад шилжүүлэх эрх зөвхөн ДГХБО-ын ОУСТ-д олгогдох;

Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд

- Судалгааны ажлыг энэхүү Ажлын удирдамжид заасан цаг тухайд нь хүлээлгэж өгөх,
- Дүн шинжилгээний цогц байдал,
- Судалгааг өндөр түвшинд Монгол хэл дээр бичсэн байх, үг үсэг ба найруулгын хувьд алдаагүй байх,
- ДГХБО-ын ОУСТ-өөс гарах судалгаатай холбоотой санал хүсэлтийг хүлээн авах, саналыг судалгаанд тусгах чадвар зэрэг багтана.

Гүйцэтгэгчид тавигдах шаардлага

- Судалгааны ажил гүйцэтгэгч нь харилцааны өндөр чадвартай, бүтээлч,
- Дүн шинжилгээ хийх чадвартай,
- Монгол Улсын болон олон улсын эдийн засаг, хөгжлийн асуудлын талаар өндөр мэдлэгтэй,
- Төсөл боловсруулах чадвар сайтай,
- Судалгааны арга зүйд мэргэшсэн,
- Гадаадын эх сурвалжуудаас мэдээлэл олж, боловсруулах чадвартай,
- Ажил төлөвлөлт, хувийн зохион байгуулалт сайн байх ёстой.

Мэргэшсэн байдал, туршлага

- Нийгэм ба эдийн засаг, хөгжлийн бодлого, тээвэр, дэд бүтэц, аялал жуулчлал, судалгааны арга зүйч эсвэл холбогдох чиглэлээр магистр эсвэл түүнээс дээш зэрэгтэй.
- Дээр дурдсан чиглэлээр судалгаа, бодлогын дүн шинжилгээ хийсэн тав ба түүнээс дээш жилийн туршлагатай байх.
- Судалгааны ажлын арвин туршлагатай байх, мөн дотоодын болон олон улсын академик сэтгүүл, журналд нийтлэлээ гаргаж байсан.
- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын чиглэлээр ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.

Үнийн санал

Үнийн саналыг ажлын арга зүй болон төлөвлөгөөнөөс тусдаа дугтуйнд ирүүлэх шаардлагатай.

Судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бүх төрлийн зардал, зөвлөх үйлчилгээний хөлс зэргийг багтаасан бөөн дүнгээр үнийн саналаа ирүүлэх ба судалгааны ажлын аргачлал, төлөвлөгөөтэй уялдуулан гаргасан энэхүү үнийн саналын задаргааг хавсаргана.

Санал болгох гэрээний үнийн дүн нь судалгааны ажлын гүйцэтгэл дээр суурьлах тул энэхүү ажлын удирдамжид заасан хугацааг сунгах эсэхээс үл хамааран тогтмол байна.

Бүрдүүлэх материал

Судалгааны ажлыг сонирхож буй Монгол Улсын иргэд дараах баримт бичиг/ мэдээллийг бүрдүүлэн цахимаар thinktank@land-locked.org хаяг руу 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 18:00 цагаас өмнө ирүүлнэ үү:

- Өмнө нь хэрэгжүүлж байсан төслүүд болон ажлын туршлагыг багтаасан хувийн намтар (CV), холбоо барих хаяг (имэйл, утасны дугаар),
- Доод тал нь хоёр тодорхойлох захидал (references).
- Судалгааны ажлын товч санал бүхий өргөдөл, үүнд: судалгааг хэрхэн гүйцэтгэхтэй холбоотой ашиглах судалгааны арга зүй; судалгааны бүтцийг урьдчилсан байдлаар танилцуулах (structure); судалгааны асуулт ба таамаглалыг (hypothesis) боловсруулах.
- Үнийн санал

Илгээсэн материалуудаас зөвхөн дараагийн шатанд шалгарсан хүмүүстэй утсаар холбогдох болно.

Баталсан:

Э.Одбаяр, Гүйцэтгэх захирал